



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/160/45

Арвайхээр сум

Бүх тендерээс татгалзах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 25 дугаар дүгнэлтийн дагуу Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 28 дугаар багц Нэг удаагийн тариур нийлүүлэх тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендерийн материал ирүүлээгүй тул бүх тендерээс татгалзсугай.

2. Дээрх хүчингүй болсон тендерийг хуулийн дагуу дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

3. Мөн Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгох тухай А/160 дугаар захирамжийн шийдвэрийн 28 дугаар багцад гаргасан шийдвэрийг хүчингүй болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0459

D:My Doc. Zahiramj. Zasag darga